

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.04 № 06/581
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сангийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сангийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын Сангийн яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherag\Yawsan_Bichig\2020\0221SAG26.Docx

001590677

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт, биет бус хөрөнгийн тайлагнал, бүртгэлийг холбогдох журмын дагуу хийхтэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сангийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж нар хариуцаж хэрэгжүүлэв.

Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 11-2/405 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сангийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилгыг Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангахад оршино гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл :

- Санхүү, төсвийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
- Санхүүгийн салбарын зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах;
- Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;
- Гадаадын санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, боловсронгуй болгох, хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавих, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг дээшлүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Санхүүгийн дотоод хяналтын бодлого, удирдлагаар хангах;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах;
- Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;

Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Сангийн яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн яамны нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолохын Acolous программ хангамж ашигладаг байна.

Сангийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сангийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 16,755.601.5 мянган төгрөгөөс тооцон 251,334.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сангийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,843,615.9 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	34,752,650.1	34,752,650.1
Авлага	1,282,092.4	172,068.4	(1,110,024.0)
Урьдчилгаа	665,111.5	658,968.6	(6,142.8)
Бараа материал	435,031.2	687,318.9	252,287.7
Нөөцийн бараа	-	2,089,793.0	2,089,793.0
Үндсэн хөрөнгө	14,373,366.6	11,238,418.5	(3,134,948.1)
Нийт хөрөнгө	16,755,601.6	49,599,217.5	32,843,615.9
Өр төлбөр	449.1	2,861,096.9	2,860,647.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	16,755,152.5	46,738,120.7	29,982,968.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,755,601.6	49,599,217.5	32,843,615.9

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Засгийн газрын 2019 оны 430 дугаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу хэрэгжиж дуусаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 31,974,843.0 мянган төгрөг, гүйцэтгэгч 15 аж ахуйн нэгж байгууллагын барьцааны баталгаа 2,777,807.1 мянган төгрөг, нийт 34,752,650.1 мянган төгрөг байна.

Авлага өмнөх оноос буурсан нь дансны үлэгдлийг татан төвлөрүүлснээс үүссэн 914,980.8 мянган төгрөгийн авлагыг буцаан авснаас голлон шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд гадаад томилолтын тийзийн үнэ 1,173.5 мянган төгрөг, гадаад хэвлэл захиалгын 4,814.9 мянган төгрөг, барьцаа хөрөнгө, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн 164,549.9 мянган төгрөг нийт 170,538.3 мянган төгрөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан авлага, 1,257.5 мянган төгрөгийн он удаан жил болсон Сэргээн босголт банкнаас авах харилцах дансны үлдэгдэл байна. Хувь хүнээс авах авлагын 1.6 мянган төгрөгийн гадаад томилолт, 271.0 мянган төгрөгийн ажилчдаас авах цалингийн авлага нийт 272.6 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 252,287.7 мянган төгрөгөөр өссөн нь аж, ахуйн бараа материал дансанд 1 жилийн ашиглалтын хугацаатай хэрэглээний болон тусгай зориулалтын программ хангамжуудыг бүртгэж 230,133.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Нөөцийн бараа дансанд яамны барилгын он дамжин хэрэгжих их засварын зардал 2,089,793.0 мянган төгрөгийг капиталжуулах зорилгоор хуримтлуулан бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 4,786,333.4 мянган төгрөг байгаагаас голлон нөлөөлсөн байна. Мөн төсвийн хөрөнгөөр 1,264,258.3 мянган төгрөг, хандив тусламжаар 273,522.4 мянган төгрөг, бусад байгууллагаас шилжүүлэн авсан 240,390.0 мянган төгрөг нийт 1,781,279.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, холбогдох тушаал шийдвэрүүдээр 201,198.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, бусад байгууллага болон бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн 230,804.4 мянган төгрөг, нийт 432,002.4 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд төсвийн 8 ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй төслүүдийн монгол талын хөрөнгө болох 44,972,116.9 мянган төгрөгийн санхүүжилтээс барьцаа хөрөнгийн дансанд суутгасан гүйцэтгэгч 15 аж, ахуйн нэгж байгууллагатай холбоотой 2,777,807.1 мянган төгрөг, яамны урсгал засварын зардлын барьцаа хөрөнгийн өглөг 83,289.7 мянган төгрөг, нийт 2,861,096.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 46,738,120.7 мянган төгрөг болж 29,982,968.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 15,408,248.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төсөвлөсөн ба гүйцэтгэлээр 13,675,858.0 төгрөгийн санхүүжилт авснаас 12,277,972.4 мянган төгрөгийг зарцуулж, 1,397,885.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж төсвийн гүйцэтгэл 79.7 хувийн биелэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Батлагдсан төсвөөс 3,130,275.8 мянган төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь дараах голлох шалтгаантай байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж 458,068.1 мянган төгрөг;
- Мэдээлэл технологийн зардал 522,173.5 мянган төгрөг;
- Засгийн газрын гадаад шилжүүлэг 1,472,665.5 мянган төгрөгөөр тус тус зарцуулалт гараагүйтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: хандив тусламжийн орлогоор 112,600.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 914,980.9 мянган төгрөг, бусад орлого 2,388.0 мянган төгрөг, нийт 1,029,968.9 мянган төгрөгийн орлогыг нэмэлт төсвийн дансанд төвлөрүүлсэн.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 114,170.1 мянган төгрөг, урсгал засварт 825,000.0 мянган төгрөг, цалинд 6,526.1 мянган төгрөг, нийт 945,696.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 84,272.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлж 81,260.2 мянган төгрөгийг буцаан авахаар авлага үүсгэн бүртгэсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 380,926.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 186,505.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 194,420.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Мөн Зардлын 8 дансанд нийт 186,505.7 мянган төгрөгийг зардал бууруулж бүртгэснийг аудитын явцад залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Сангийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулан ажилласан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 19,100.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Сангийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгийн дансанд 681,002.1 мянган төгрөгийн дансны үнэтэй 167,049.1 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 43 нэр төрлийн ашиглагдахгүй программ хангамж бүртгэлтэй байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1 "элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", мөн журмын 6.2.3 "техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон" тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт сул, тооллого тооцоо үнэн зөв хийгдэхгүй, үр дүн буруу илэрхийлэгдэх, үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа 681,002.1 мянган төгрөгийн дансны үнэтэй 167,049.1 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 43 нэр төрлийн ашиглагдахгүй программ хангамжийг холбогдох хууль, журмын дагуу данснаас хасч шийдвэрлэх, үр дүнг тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

2. Үндсэн хөрөнгийн анхан шатны баримттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Татварын цахим системийн бүртгэлд 27,371.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан э-баримт бүртгүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг тус хэрэгжүүлж ажиллаагүй байна

2.2. Эрсдэл: НӨАТ-ын буцаан олголтыг бусад этгээд ашиглан авсан байх, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа э-баримтыг татварын цахим системд бүрэн бүртгэж, хяналт тавин ажиллаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,382,235,018.11</u>	<u>38,360,799,057.95</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	34,752,650,139.88
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	34,752,650,139.88
3121	Төгрөг	00.00	34,752,650,139.88
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	34,752,650,139.88
33	АВЛАГА	1,282,092,374.31	172,068,368.77
335	Бусад авлага	1,282,092,374.31	172,068,368.77
3351	Байгууллагаас авах авлага	1,280,890,717.03	171,795,770.03
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,201,657.28	272,598.74
34	УРЬДЧИЛГАА	665,111,451.34	658,968,639.21
34600	Урьдчилж гарсан зардал	665,111,451.34	658,968,639.21
35	БАРАА МАТЕРИАЛ	435,031,192.46	687,318,889.08
351	Түүхий эд материал	00.00	223,792,075.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	20,196,400.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	203,595,675.00
354	Хангамжийн материал	435,031,192.46	463,526,814.08
35410	Бичиг хэргийн материал	12,931,200.00	16,370,700.00
35420	Аж ахуйн материал	379,448,628.46	368,521,161.68
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	11,171,100.00
35440	Түлш, шатах тослох материал	6,461,364.00	8,147,859.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	11,935,993.40
35600	Мал амьтад	36,190,000.00	47,380,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	00.00	2,089,793,021.01
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	00.00	2,089,793,021.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,373,366,561.29</u>	<u>11,238,418,470.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>14,373,366,561.29</u>	<u>11,238,418,470.43</u>
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	11,277,965,242.29	10,666,708,212.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,002,876,326.00	7,949,796,326.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-145,950,019.47	-290,742,322.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	427,513,623.81	616,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-122,808,095.81	-212,608,172.93
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,513,355,966.19	8,402,317,524.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,729,915,191.66	-6,168,380,318.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	822,994,264.53	913,124,698.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-494,308,435.30	-548,942,826.98
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	1,236,500.00
39217	Ном	4,206,804.00	4,206,804.00
393	Биет бус хөрөнгө	3,095,401,319.00	571,710,258.15
39301	Програм хангамж	3,844,782,820.86	4,074,516,305.86
39302	Хуримтлагдсан элэгдэл	-768,939,021.86	-3,525,472,047.71
39303	Бусад биет бус хөрөнгө	19,557,520.00	22,666,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>16,755,601,579.40</u>	<u>49,599,217,528.38</u>

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	449,090.90	2,861,096,863.55
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	449,090.90	2,861,096,863.55
413	Өглөг	449,090.90	2,861,096,863.55
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	449,090.90	2,861,096,863.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,755,152,488.50	46,738,120,664.83
51	Засгийн газрын хувь оролцоо	16,755,152,488.50	46,738,120,664.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,952,641,607.17	5,955,750,087.17
51101	Өмч: - төрийн	5,952,641,607.17	5,955,750,087.17
512	Хуримтлагдсан үр дүн	7,417,749,785.17	37,397,609,481.50
51210	Өмнөх үеийн үр дүн	7,417,749,785.17	7,417,749,785.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	29,979,859,696.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,384,761,096.16	3,384,761,096.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,755,601,579.40	49,599,217,528.38

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	26,767,761,874.22	91,087,579,321.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,667,058,615.91	532,161,419.04
120	Нийтлэг татварын бус орлого	1,667,058,615.91	532,161,419.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,667,058,615.91	520,099,919.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,725,972.67	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,664,866,762.24	520,099,919.04
120009	Бусад орлого	465,881.00	12,061,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,100,703,258.31	90,555,417,902.58
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	23,856,242,373.00	90,442,817,902.58
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,592,603,800.00	13,675,858,030.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	31,974,842,991.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	11,263,638,573.00	44,792,116,881.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,244,460,885.31	112,600,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	114,622,280.00	112,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,100,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,022,478,605.31	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,260,000.00	2,388,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	24,137,205,993.81	61,037,212,270.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,926,647,420.81	61,037,212,270.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,847,796,852.12	58,223,842,240.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,251,612,392.75	2,518,040,180.93
210101	Үндсэн цалин	2,251,612,392.75	2,262,417,269.31
210102	Нэмэгдэл	00.00	179,670,911.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	75,952,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	278,309,550.89	322,197,301.76
210201	Тэтгэврийн даатгал	187,406,916.72	220,753,382.23
210202	Тэтгэмжийн даатгал	23,187,991.47	26,038,518.34

210203	ҮОМШӨ-ний даатгал	18,241,285.79	20,120,414.07
210204	Ажилгүйдлийн даатгал	4,464,827.73	4,983,952.44
210205	Эрүүл мэндийн даатгал	45,008,529.18	50,301,034.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,679,025.80	170,975,228.79
210301	Гэрэл, цахилгаан	115,337,858.80	121,865,126.79
210302	Түлш, халаалт	29,298,702.00	33,107,719.00
210303	Цэвэр, бохир ус	6,277,215.00	10,137,983.00
210304	Байрны түрээс	19,765,250.00	5,864,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	238,300,461.04	272,871,252.89
210401	Бичиг хэрэг	59,241,000.00	73,973,754.00
210402	Тээвэр, шатахуун	25,386,155.00	29,937,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,983,955.00	33,044,764.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,565,300.00	2,348,050.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	118,124,051.04	133,566,784.80
2105	Нормативт зардал	00.00	762,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	762,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,265,235.00	18,905,767.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,258,400.00	4,251,500.00
210604	Урсгал засвар	10,006,835.00	14,654,267.00
2107	Томилолт, зочны зардал	64,537,121.00	108,232,935.00
210701	Гадаад албан томилолт	00.00	745,600.00
210702	Дотоод албан томилолт	31,644,169.00	52,426,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	32,892,952.00	55,060,735.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,722,846,678.04	48,418,852,763.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,654,035,085.68	47,798,759,336.43
210803	Даатгалын үйлчилгээ	4,985,516.50	5,981,641.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	571,833.00	551,364.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	63,040,226.86	613,345,581.46
210807	Газрын төлбөр	93,016.00	126,840.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,109,246,387.60	6,393,004,710.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	633,545,872.81	1,606,671,252.35
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,475,700,514.79	4,786,333,458.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,078,850,568.69	2,813,370,029.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,100,552,808.66	796,209,362.35
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,100,552,808.66	796,209,362.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	341,575,048.34	300,330,256.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	144,075,048.34	251,794,672.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	18,980,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	197,500,000.00	29,555,284.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,636,722,711.69	1,716,830,411.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,636,722,711.69	1,716,830,411.21
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,210,558,573.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,210,558,573.00	00.00
220001	Барилга байгууламж	11,210,558,573.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,630,555,880.41	30,050,367,051.45
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,616,768.52	70,507,355.13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	22,436,768.52	46,938,826.95
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	9,180,000.00	23,568,528.18
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-31,616,768.52	-70,507,355.13
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,598,939,111.89	29,979,859,696.32

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	25,104,043,139.31	94,260,267,436.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,339,881.00	2,787,480,648.88
120	Нийтлэг татварын бус орлого	3,339,881.00	2,787,480,648.88
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,339,881.00	
120009	Бусад орлого		2,787,480,648.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,100,703,258.31	91,472,786,787.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	23,856,242,373.00	90,442,817,902.58
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,592,603,800.00	13,675,858,030.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		31,974,842,991.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	11,263,638,573.00	44,792,116,881.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,244,460,885.31	1,029,968,885.31
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	114,622,280.00	199,342,280.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,100,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,022,478,605.31	824,978,605.31
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,260,000.00	5,648,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	13,344,590,338.54	13,996,592,745.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,344,590,338.54	13,996,592,745.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,349,004,594.88	11,019,836,558.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,254,534,422.42	2,519,694,954.47
210101	Үндсэн цалин	1,374,180,886.93	1,468,877,638.00
210102	Нэмэгдэл	627,080,667.49	788,714,386.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	253,272,868.00	255,384,130.66
210104	Урамшуулал	00.00	6,718,799.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	272,296,011.28	319,617,503.47
210201	Тэтгэврийн даатгал	257,994,677.75	294,617,503.47
210202	Тэтгэмжийн даатгал	14,301,333.53	25,000,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,679,025.80	170,975,228.79
210301	Гэрэл, цахилгаан	113,674,645.80	121,865,126.79
210302	Түлш, халаалт	29,665,664.00	33,107,719.00
210303	Цэвэр, бохир ус	7,573,466.00	10,137,983.00
210304	Байрны түрээс	19,765,250.00	5,864,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	140,762,363.80	146,736,534.14
210401	Бичиг хэрэг	62,519,250.00	46,435,924.00
210402	Тээвэр, шатахуун	25,025,903.80	30,952,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,983,955.00	38,139,684.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,233,255.00	31,208,626.00
2105	Нормативт зардал	00.00	927,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	927,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	260,276,845.40	880,536,291.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,259,003.40	35,999,941.00
210604	Урсгал засвар	235,017,842.00	844,536,350.00

2107	Томилолт, зочны зардал	64,537,121.00	103,209,254.00
210702	Дотоод албан томилолт	31,644,169.00	29,229,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	32,892,952.00	73,979,554.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,494,659,331.48	4,802,429,745.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,277,055,823.38	3,912,154,363.87
210803	Даатгалын үйлчилгээ	5,364,429.00	5,112,954.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	571,833.00	551,364.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	211,439,942.10	884,396,223.90
210807	Газрын төлбөр	106,304.00	126,840.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	691,259,473.70	2,075,709,946.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	691,259,473.70	2,075,709,946.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,995,585,743.66	2,976,756,186.82
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,100,552,808.66	796,209,362.35
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,100,552,808.66	796,209,362.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	343,329,338.00	299,166,478.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	145,829,338.00	250,186,694.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	18,980,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	197,500,000.00	29,999,484.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,551,703,597.00	1,881,380,346.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,551,703,597.00	1,881,380,346.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,759,452,800.77	80,263,674,691.75
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,759,452,800.77	45,511,024,551.87
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,759,452,800.77	45,511,024,551.87
2200	Дотоод эх үүсвэрээр	11,759,452,800.77	45,511,024,551.87
220001	Барилга байгууламж	11,263,638,573.00	44,393,868,261.62
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	495,814,227.77	1,117,156,290.25
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	11,759,452,800.77	-45,511,024,551.87
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	34,752,650,139.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	34,752,650,139.88

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	5,933,084,087.17	74,963,143.86	4,818,810,673.28	10,826,857,904.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,933,084,087.17	74,963,143.86	4,818,810,673.28	10,826,857,904.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	3,309,797,952.30	00.00	3,309,797,952.30
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	19,557,520.00	00.00	00.00	19,557,520.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,598,939,111.89	2,598,939,111.89
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,952,641,607.17	3,384,761,096.16	7,417,749,785.17	16,755,152,488.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,952,641,607.17	3,384,761,096.16	7,417,749,785.17	16,755,152,488.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	3,108,480.00	00.00	00.00	3,108,480.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,979,859,696.32	29,979,859,696.32
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,955,750,087.17	3,384,761,096.16	37,397,609,481.49	46,738,120,664.82

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,408,248,300.00	12,277,972,423.80	3,130,275,876.20	79.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,408,248,300.00	12,277,972,423.80	3,130,275,876.20	79.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,820,918,100.00	11,182,596,583.45	1,638,321,516.55	87.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,945,802,800.00	2,513,168,789.47	432,634,010.53	85.31
210101	Үндсэн цалин	1,642,798,400.00	1,462,351,473.00	180,446,927.00	89.02
210102	Нэмэгдэл	785,732,000.00	788,714,386.26	(2,982,386.26)	100.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	269,274,000.00	255,384,130.66	13,889,869.34	94.84
210105	Урамшуулал	247,998,400.00	6,718,799.55	241,279,600.45	2.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	370,598,000.00	319,617,503.47	50,980,496.53	86.24
210201	Тэтгэврийн даатгал	302,006,600.00	294,617,503.47	7,389,096.53	97.55
210202	Тэтгэмжийн даатгал	29,647,800.00	25,000,000.00	4,647,800.00	84.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,718,300.00		23,718,300.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	5,929,600.00		5,929,600.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	9,295,700.00		9,295,700.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	179,000,100.00	170,975,228.79	8,024,871.21	95.52
210301	Гэрэл, цахилгаан	123,396,900.00	121,865,126.79	1,531,773.21	98.76
210302	Түлш, халаалт	38,157,400.00	33,107,719.00	5,049,681.00	86.77
210303	Цэвэр, бохир ус	11,555,900.00	10,137,983.00	1,417,917.00	87.73
210304	Байрны түрээс	5,889,900.00	5,864,400.00	25,500.00	99.57
2104	Хангамж, бараа материалын зардал	167,929,900.00	152,115,234.14	15,814,665.86	90.58
210401	Бичиг хэрэг	57,887,000.00	46,740,924.00	11,146,076.00	80.75
210402	Тээвэр, шатахуун	31,268,500.00	30,952,300.00	316,200.00	98.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,427,400.00	38,139,684.14	2,287,715.86	94.34
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,347,000.00	36,282,326.00	2,064,674.00	94.62
2105	Нормативт зардал	990,000.00	927,100.00	62,900.00	93.65
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	990,000.00	927,100.00	62,900.00	93.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	213,000,000.00	192,723,646.50	20,276,353.50	90.48
210601	Багаж, техник, хэрэгсэл	190,000,000.00	173,187,296.50	16,812,703.50	91.15
210604	Урсгал засвар	23,000,000.00	19,536,350.00	3,463,650.00	84.94
2107	Томилолт, зочны зардал	111,841,300.00	103,209,254.00	8,632,046.00	92.28
210702	Дотоод албан томилолт	35,183,300.00	29,229,700.00	5,953,600.00	83.08
210703	Зочин төлөөлөгч хүлэн авах	76,658,000.00	73,979,554.00	2,678,446.00	96.51
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,757,101,100.00	5,775,783,480.52	981,317,619.48	85.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,262,425,900.00	4,804,357,813.62	458,068,086.38	91.30
210803	Даатгалын үйлчилгээ	5,979,000.00	5,112,954.00	866,046.00	85.52

210804	Тээврийн хэрэгслийн татвар	726,800.00	551,364.00	175,436.00	75.86
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,000.00	88,000.00	34,000.00	72.13
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,487,720,000.00	965,546,508.90	522,173,491.10	64.90
210807	Газрын төлбөр	127,400.00	126,840.00	560.00	99.56
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,074,654,900.00	1,954,076,346.56	120,578,553.44	94.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,074,654,900.00	1,954,076,346.56	120,578,553.44	94.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,587,330,200.00	1,095,375,840.35	1,491,954,359.65	42.34
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,268,874,900.00	796,209,362.35	1,472,665,537.65	35.09
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,268,874,900.00	796,209,362.35	1,472,665,537.65	35.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	318,455,300.00	299,166,478.00	19,288,822.00	93.94
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	266,225,000.00	250,186,694.00	16,038,306.00	93.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,980,300.00	18,980,300.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	33,250,000.00	29,999,484.00	3,250,516.00	90.22
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,408,248,300.00	12,277,972,423.80	3,130,275,876.20	79.68
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,408,248,300.00	12,276,998,923.80	3,131,249,376.20	79.68
310001	Улсын төсвөөс санхүүжих	15,408,248,300.00	12,276,998,923.80	3,131,249,376.20	79.68
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		973,500.00	-973,500.00	
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		973,500.00	-973,500.00	
	Тохируулсан орлого, зардал дүн		34,752,650,139.88		
Мөнгөн хөрөнгийн эцийн үлдэгдэл			34,752,650,139.88		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	167	167	-	100.00
620001	Удирдах ажилтан	13	13	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	149	149	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,029,968,885.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,029,968,885.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	945,696,265.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,526,165.00
210101	Үндсэн цалин	6,526,165.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	825,000,000.00
210604	Урсгал засвар	825,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,170,100.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,075,600.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,094,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,272,620.30
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	84,272,620.30
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	84,272,620.30
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,029,968,885.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,029,968,885.31
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	199,342,280.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	824,978,605.31
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,648,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.20	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/23/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайлангийн аудит		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулл агаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Биет бус хөрөнгийн дансанд 681,002.1 мянган төгрөгийн дансны үнэтэй 167,049.1 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 43 нэр төрлийн ашиглагдахгүй программ хангамж бүртгэлтэй байна.	167,049.1	Зөвлөмж өгөх	Ахлах мэрэгжилтэн, Ерөнхий ня-бо	Б.Мягмарсүрэн
2	Татварын цахим системийн бүртгэлд 27,371.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан э-баримт бүртгүүлээгүй байна.	27,371.6	Зөвлөмж өгөх	Ахлах мэрэгжилтэн, Ерөнхий ня-бо	Б.Мягмарсүрэн
	Нийт дүн	194,420.7			

[illegible]

[illegible]